

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар нь МХЕГ-аас 2020 оныг "Хамтын хяналт-аюулгүй байдал" болгон зарласантай холбогдуулан мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, ард иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, иргэд, бизнес эрхлэгчдын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, эрсдэлийг үнэлгээг илүү оновчтой хийх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, үр дүнгээ тооцон ажилласан.

2020 оны эхний хагас жилд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар нь Төсвийн төвлөрүүлэн захирагч буюу МХЕГ-ын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр нийт 74 ажил үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тамгын газар, 8 хэлтэс, Төв лаборатори, 8 дүүрэгт Мэргэжлийн хяналтын хэлтэс, Багахангай дүүрэгт Мэргэжлийн хяналтын тасагтайгаар нийт 527 хүний бүрэлдэхүүнтэйгээр 54808 хүн/өдөр ажиллахаас 58/1156 хүн/өдөр ээлжийн амралттай, 75/781 хүн/өдөр чөлөөтэй, 105/472 хүн/өдөр өвчтэй, нийт 57217 хүн/өдөр ажилласан байна.

2020 оны эхний хагас жилд Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол дахь Мэргэжлийн хяналтын байгууллагатай холбоотой заалтууд 81.1%, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 100%, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт 81%-тай тус тус хэрэгжсэн.

Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй, шударга, шуурхай, ил тод байдлыг дээшлүүлэн, цахим системийг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

НЭГ: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1.1. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний 29, Улаанбаатар хотын Ерөнхий Менежерийн 6, МХЕГ-ын цахим шуурхай хуралдааны 50, НМХГ-ын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний 84, нийт 169 үүрэг даалгаврын биелэлтийг 100% биелүүлэн ажилласан.

НМХГ-ын даргын дэргэдэх Зөвлөлийн 2 удаагийн хурлаар 2 асуудал хэлэлцэж, гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, цахим хуудсанд хурлыг шийдвэрүүдийг тухай бүр байршуулсан.

"2020 онд хийх хяналт шалгалтын календарчилсан төлөвлөгөө", "НМХГ-аас МХЕГ болон төрийн бусад байгууллагуудад мэдээ, тайлан, төлөвлөгөөний биелэлт хүргүүлэх хуваарь", "НМХГ-ын 2020 онд хийх сургалтын календарчилсан төлөвлөгөө" гаргаж, дотоод үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

Удирдах ажилтан, улсын байцаагчдын ажлын хариуцлага, сахилга, гүйцэтгэл, үр дүнг дээшлүүлэх зорилгоор удирдах ажилтан, улсын байцаагч, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг сар, улирал, хагас, бүтэн жилээр гүйцэтгэлийг дүгнэн хариуцлага тооцон ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, санхүү, хяналт шалгалтын ил тод байдлыг ханган, цахим хуудас, шилэн данс, шилэн хяналтын цахим систем, мэдээллийн самбарт мэдээ мэдээллийг сар бүр шинэчлэн оруулсан.

Хүрсэн үр дүн: Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны шуурхай байдал дээшилсэн.

Хүний нөөцийн үйл ажиллагааг зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангана.

1.2. Хүний нөөцийн үйл ажиллагааны талаар:

Тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.

Төрийн албан хаагчдын “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, биелэлтийг хангуулсан.

Засгийн газрын 2019 оны 472, 2019 оны 24 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд НМХГ-ын даргын 2020 оны А/04 дүгээр тушаалаар нийт албан хаагчдын цалин, төрийн алба хаасан хугацааны, ур чадварын нэмэгдлийг шинэчлэн тогтоосон.

Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан байгууллагын албан хаагчдын зэрэг дэв, түүний нэмэгдлийн өнөөгийн байдлыг тодорхойлох, санхүүгийн тооцоолол болон албан хаагчдын хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэрт үзлэг хийх, ажилласан жилийг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг НМХГ-ын даргын 2020 оны А/04 дүгээр тушаалаар баталсан. Монгол Улсын Шадар сайдын 99 дүгээр тушаал, нийт 334 албан хаагчдад ажилласан жилийн нэмэгдэл хувийг нэмэгдүүлэн олголоо.

Түүнчлэн албан хаагчдын бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланд нийт 527 албан хаагчдын хувийн мэдээллийг бүртгэлжүүлж, албан хаагчдын төрийн албан хаагчийн судалгаагаар мэдээллийн сан үүсгэсэн.

2020 оны эхний хагас жилд 48 улсын /ахлах/ байцаагчийн эрх цуцлуулах, 36 улсын /ахлах/ байцаагчийн эрх олгуулах, 22 улсын байцаагчийн эрх сунгуулах саналуудыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

Шинээр томилогдсон 62, шилжүүлэн томилсон 45, ажлаас чөлөөлөгдсөн 19 албан хаагчийн Нийгмийн даатгалын дэвтэр, 129 албан хаагчийн эмнэлгийн хуудсанд бичилт хийж, “Ээлжийн амралтын хуваарь батлах тухай” тушаалын дагуу 120 ажилтан, албан хаагчийн ээлжийн амралтын мэдэгдлийг өгч биеэр эдлүүлээд байна.

Хүний нөөцийн асуудлаар 199 өргөдөл, 208 албан бичгийг хугацаанд нь 100% шийдвэрлэн, 193 албан бичиг боловсруулан иргэн, аж ахуй нэгж байгууллагад хүргүүлэн хариуг erp.ulaanbaatar.mn программд орууллаа.

Ерөнхий менежер, нэгжийн менежерийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын төрийн захиргааны 447 албан хаагчид ерөнхий менежертэй гүйцэтгэлийн төлөвлөгөө, Нууцын баталгааны батламж, ашиг сонирхлын гэрээ байгуулж, 75 төрийн үйлчилгээний ажилтантай хөдөлмөрийн гэрээ, нийт албан хаагчидтай ёс зүйн болон хариуцлагын гэрээг тус тус байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол Нийслэлийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1016, 10 дугаар сарын 24-ний өдрийн “Түүхий нүүрсний тээвэрлэлт, хэрэглээнд хяналт тавих тухай” А/1118 дугаар захирамж, нийслэлийн Онцгой комиссын даргын 2019 оны 07 дугаар тушаал, 06, 07, 08, 09, 10, 11, 12 дугаар хурлын шийдвэр, нийслэлийн Онцгой комиссын орлогч даргын баталсан Нутгийн захиргааны байгууллагуудын хамтран ажиллах төлөвлөгөө, шуурхай штабт үүрэг гүйцэтгүүлэх албан хаагчдын хуваарь эрх зүйн баримт бичгийг удирдлага болгож, Нийслэлийн шуурхай штабт хуваарийн дагуу албан хаагчид үүрэг гүйцэтгэсэн.

Албан хаагчдын ажилласан жилийн судалгааг Нийгмийн хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчаар баталгаажуулсан.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, гамшгийн үед ажиллах албан хаагчдын, 2020, 2021 онд тэтгэвэрт гарах албан хаагчдын, хүүхэд асрах чөлөөтэй байгаа албан хаагчдын, ажилласан жил, зэрэг дэвийн, ажилдаа ирэх буцахдаа зорчдог тээврийн хэрэгслийн, ээлжийн амралтын судалгааг гаргаж холбогдох байгууллага, хэлтэст хүргүүлсэн.Албан хаагчдын ажилласан жилийн судалгааг Нийгмийн хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчаар баталгаажуулсан.

НМХГ-т шинээр томилогдох, сэлгэн ажиллах, албан тушаал ахиулах 73 албан хаагчийн Ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг холбогдох баримт бичгийн хамт Авлигатай тэмцэх газарт хянуулсан.

Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөл, МХЕГ-ын Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлдсүл 27 орон тооны захиалгыгалбан бичгээр тус тус хүргүүлэн ажилласан.

“UB ERP” дотоод удирдлагын систем, Able хүний нөөцийн цахим программд шинээр томилогдсон 8 албан хаагчдын бүртгэл мэдээллийг бүртгэн оруулсан.

Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 1 албан хаагчид 680,000 төгрөг, 1 улсын /ахлах/ байцаагч өвчний улмаас нас барсан тул 100,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгож,2020 онд өндөр насны тэтгэвэрт гарах 21 албан хаагчийн 12-36 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмжийг төсөвт суулгаж өгсөн.

Засгийн газрын 2020 оны “Шинэ короновирусийн эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 30 дугаар тогтоол, 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 62 дугаар тогтоол, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын даргын тушаал Б/134 дугаарын тушаалаар 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтан, албан хаагчдад 5 хоногийн цалинтай чөлөөг 153 албан хаагчдад олгосон. Мөн албан хаагчдын хүсэлтийн дагуу 59 албан хаагчдад цалинтай чөлөө олгож, 10 албан хаагчид цалингүй чөлөө олгосон.

Төрийн албаны зөвлөлийн 379 дүгээр тушаалаар тус газрын 30 албан тушаалын тодорхойлолт баталсаны дагуу НМХГ-ын даргын А/44 дүгээр тушаалаар 117 албан тушаалын тодорхойлолт батлуулсан. Мөн НМХГ-ын Тамгын газар, хэлтэс, Чиглэл, Дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, Төв лабораторийн албан хаагчдын ээлжийн амралт, эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар албан үүргийг нь түр орлон гүйцэтгэх албан хаагчдын жагсаалтыг НМХГ-ын даргын Б/209 дүгээр тушаалаар баталсан. Засгийн газрын 2009 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 143 дугаар тогтоолын дагуу байгууллагын бүтэц, орон тоо, хүний нөөцийн ил тод байдлыг хангах, мэдээллийг вэб сайтад байршуулж, тогтмол шинэчилж байна.

- Төрийн албан хаагчийн ёс зүй манлайлал, сахилга хариуцлагын талаар

Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах ажлын хүрээнд удидах ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сар, улирлаар дүгнэн, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн 43 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулж, давхардсан тоогоор 244 албан хаагчид анхааруулах хуудас өгсөн.

Байгууллагын “Ёс зүйн хороо”-нд ирсэн 3 өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж, ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон 2 улсын /ахлах/ байцаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн.

-Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх талаар

“НМХГ-ын 2020 онд хийх сургалтын календарчилсан төлөвлөгөө”-ний дагуу чиглэлийн болон дүүрэг дэх МХХ-үүдээс албан хаагчдад 73 дотоод сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 978 албан хаагчийг хамруулсан. Удирдлагын Академи ба Төрийн албаны зөвлөлийн хамтарсан 37/33 тоот тушаалын 3.2-т заасны дагуу Ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд хууль, тогтоомжид заасны дагуу томилогдон ажиллаж байгаа 19 албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад зайн хэлбэрээр хамруулсан.

Хүрсэн үр дүн: Хүний нөөцийн чадавхи сайжирсан. Мэдээллийг “Able cloud” программд оруулснаар үйл ажиллагааны ил тод байдал хангагдаж, ажлын хариуцлага, сахилга, дэг журам сайжирсан.

1.3. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

Байгууллагын баримт бичгийг хуулийн хүрээнд боловсруулах чиглэлээр НМХГ-ын даргын 312 тушаал, 125 албан бичиг, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан 15 гэрээнийхууль эрх зүйн үндэслэлийг хянаж, давхардсан тоогоор 455 улсын байцаагчдад хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн.

“Авлигын эсрэг хууль”, “Авлигын үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 351 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд баталгаажуулан тайлан мэдээг МХЕГ-т хүлээлгэн өгч, их хэмжээний өөрчлөлтөөр 3 албан хаагчийн ХАСХОМ-ийг хянан баталгаажуулж, шинээр томилогдсон 33 албан хаагчийн ХАСХОМ-ийг цахим мэдээллийн санд бүртгэсэн.

НМХГ-ын даргын баталсан “Авлигын эсрэг 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсэг хяналт тавин ажиллаж байна.

Байгууллагыг хууль шүүхийн байгууллагад төлөөлөх ажлын хүрээнд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх 23, иргэний хэрэг шийдвэрлэх 21, нийт давхардсан тоогоор 257 удаагийн ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан.

Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан эд зүйл, бараа бүтээгдэхүүнийг улсын орлого болгох, устгах ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий Нийслэлийн зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд хууль тогтоомж зөрчсөн, стандартын шаардлага хангаагүй 774 нэр төрлийн 78 818 308 төгрөгийн үнэ бүхий 42666 ширхэг бараа бүтээгдэхүүнийг устгаж, /ахлах/ байцаагчдын 102 акт бүхий хэрэглэх хугацаа дууссан бүтээгдэхүүнийг устгасан.

Хууль тогтоомжийн хэрэгжүүлэх, албан хаагчдын эрх зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр "Ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, "Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг, баталгаажуулах нь": Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэгээ үнэн зөв, бодитой мэдүүлэх, баталгаажуулах, "Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа": Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулга, хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, албадлагын ажиллагааны талаар, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиуд болон "Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага" стандарт, Зөрчлийн хэрэг бүртгэлт, дугаар олголт: НМХГ-ын даргын 2019 оны А/99 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад үйлдэх эрх зүйн баримт бичигт нэгдсэн дугаар олгох, бүртгэхсэдэвт дотоод сургалтуудыг зохион байгуулж, 838 нийт албан хаагчийг хамруулсан.

Тайлант хугацаанд 4 хууль, 2 дүрэм журам, 1 стандартад санал өгч, 1 журамд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасныг үндэслэн хүн хуулийн этгээд албан тушаалтнаас гаргасан зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл болон хяналт шалгалтаар илэрсэн 795 зөрчлийг бүртгэн дугаар олгож, зөрчлийн хэрэг бүртгэлтийн мэдээг сар бүрт нэгтгэн, улирал тутам Мэргэжлийн хяналтын Ерөнхий газарт хүргүүлсэн.

Тус газрын чиглэлийн хэлтсийн эрх бүхий албан тушаалтнуудын зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ажиллагааны 614 тэмдэглэлийг бүртгэж, шийдвэрлэлтийн мэдээг сар бүр Нийслэлийн Прокурорын газарт хүргүүлэв.

Хүрсэн үр дүн: Байгууллагын эрхзүйн орчин сайжирч, баримт бичгүүд хууль тогтоомжийн хүрээнд боловсруулагдаж, албан хаагчдын эрх зүйн мэдлэг чадварыг нэмэгдүүлж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлсэн.

1.4.Эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэхэд соён гэгээрүүлж, зөвлөн тусалж, хэрэглэгч, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажилласан талаар:

НМХГ-аас 2020 оны эхний хагас жилд 1 төрийн байгууллага, 6 төрийн бус байгууллага мэргэжлийн холбоодтой хамтран хууль тогтоомжийн хангах чиглэлээр хамтран ажиллаж, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний төв, Хийн аюулгүй байдлыг хангах талаар “Газком” ХХК, Нийслэлийн Сэтгүүлчдийн холбоо, Монголын Хөдөлмөрийн Эрүүл Ахуйн Үндэсний холбоо” ТББ, “Лигал Сорс” ХХК, “Эмч эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн боловсрол ба эрүүл мэндийг хамгаалах” ТББ, “Монголын Шүдний Мэргэжилтний Холбоо” ТББ-уудтай тус тус хамтран ажиллах санамж бичиг байгуулан, санамж бичгийн хүрээнд төлөвлөгөө гарганхяналт шалгалтын давхардлыг бууруулах арга хэмжээг авч ажиллаж байна.

Хүрсэн үр дүн: Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо сайжирч, хяналт шалгалтын давхардлыг арилгах, бизнес эрхлэгчдэд учрах хүндрэл бэрхшээлийг арилгах ажилд ахиц гарч, хууль сахин мөрдөлт сайжирсан.

Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтийг мэдээллээр хангах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

1.5 Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаа, хяналт шалгалтын ажил, үр дүнг олон нийтэд сурталчилсан талаар:

“Байгууллагын ил тод байдал”-ын төлөвлөгөөг батлуулан, биелэлтийг хангуулан ажиллалаа.

НМХГ-аас 25 удаа хэвлэлийн бага хурал, 2 удаа телевизийн нэвтрүүлэг, 9 удаа телевизийн зочны ярилцлага, хэлэлцүүлэгт оролцож, телевизэд 430, FM радиогоор 44,

өдөр тутмын сонин хэвлэлээр 76, мэдээллийн вэб сайтуудад 379,125 сэдвийн мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд өгсөн.

Байгууллагын цахим хуудсанд хяналт шалгалттай холбоотой 805 зөвлөмж, 136 сэрэмжлүүлэг, 19 сургалтын мэдээ зэрэг нийт 1686 мэдээллийг нийтэлж олон нийтэд хүргэлээ.

“Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар” пэйж хуудасны дагагчийн тоо 57429-д хүрч, 2429-оор нэмэгдлээ.

Хүрсэн үр дүн: НМХГ-ын үйл ажиллагаа, хяналт шалгалтын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлах үйл ажиллагаа ил тод нээлттэй болж, удирдлага, иргэд олон нийт мэдээллээр хангагдсан.

1.6. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор хийсэн ажил, сургалт, зөвлөмж, мэдэгдэл:

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “НМХГ-ын 2020 онд хийх сургалт, зөвлөн туслах үйлчилгээний календарчилсан төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж нийт 1015 байгууллага, аж ахуйн нэгж, 11275 ажилтан, иргэнд 84 сургалтыг зохион байгуулсан.

2020 оны эхний хагас жилд 27 хяналтын чиглэлээр 205 зөвлөмжийг 8768 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд, 229 мэдэгдлийг, 35030 аж ахуйн ахуйн нэгж, байгууллагад тус тус хүргүүлж болзошгүй эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлж ажиллалаа.

Хүрсэн үр дүн: Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хууль тогтоомж, стандартын мэдлэг, мэдээллийг өгч, зөвлөн тусалж ажилласнаар болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

1.7 Архив, албан бичиг, хүсэлт, гомдлын шийдвэрлэлтийн талаар:

Албан бичиг шийдвэрлэлтийн талаар:

Тайлант хугацаанд НМХГ-ын хэмжээнд 6407 албан бичиг ирснээс хариутай 3824 (98.7%), хариугүй 2583 (99.43%) албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 3463 өргөдөл, гомдол ирснээс 3122 (90.1%) хуулийн хугацаанд шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа 301 (8.7%), хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 40 (1.2%) байна.

Хагас жилийн байдлаар 3221 гадагш явуулсан албан бичиг, 53 улсын байцаагчийн акт, 396 албан шаардлага, 35 дүгнэлт, 266 удирдамж, 15 зөвлөмж, 3 хяналт шалгалтын танилцуулгад нэгдсэн дугаар олгогдсон байна.

Албан хаагчдад www.edoc.ub.gov.mn программыг бүрэн нэвтрүүлж албан бичгийн бүртгэл шилжүүлэлт, шийдвэрлэлтэд удирдах ажилтан, албан хаагч бүрээр 7 хоног, сар, улирлаар хяналт тавин ажиллаж, албан бичиг, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй 40 албан хаагчдад “Анхааруулах хуудас” өгч хариуцлага тооцон ажилласан.

Хүрсэн үр дүн: Албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу явуулж, албан бичгийн нэгдсэн цахим программтай болсноор шийдвэрлэлтэд тавих хяналт сайжирсан.

Архивын үйл ажиллагаа:

Тамгын болон чиглэл, дүүргүүд дэх Мэргэжлийн хяналтын хэлтсүүдээс Хэрэг хөтлөх нийтлэг журмын дагуу 2019 оны нийт 18100 баримтыг хүлээн авсан.

НМХГ-аас лавлагаа мэдээлэл хүссэн 22 албан бичиг, 5 өргөдлийг шийдвэрлэн 223 баримтыг хуулбарыг баталгаажуулж олгосон.

Хүрсэн үр дүн: Холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажилласнаар байгууллагын архивын үйл ажиллагаа, архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт хангагдсан.

Шуурхай алба:

Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, шуурхай үйлчлэх зорилгоор Шуурхай албыг 24 цагаар ажиллуулж, 2008 өргөдөл, гомдлыг хүлээн авч, 1828 (89.9%) асуудлыг шийдвэрлэсэн, 180 (10.1%) нь шийдвэрлэх шатандаа байна. Нийт 16 ослын дуудлага хүлээн авч, МХЕГ-ын даргын 2015 оны 161 дүгээр тушаалын хавсралт хүснэгтийн дагуу тухай бүр холбогдох хэлтсүүдэд хүргүүлэн шийдвэрлэсэн.

Хүрсэн үр дүн: Шуурхай албаны байнгын бэлэн байдал хангагдаж, ослын үед холбогдох арга хэмжээг түргэн шуурхай авч хэрэгжүүлсэн.

Мэдээлэл технологийн чиглэлээр

НМХГ-ын албан хаагчдын дотоод сүлжээ, компьютер техник хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хуваарь гаргаж, засвар үйлчилгээ хийж гүйцэтгэсэн.

Тайлант хугацаанд албан хаагчдын 171 компьютер, 67 принтерт засвар үйлчилгээ хийж, чиглэлийн болон дүүргүүд дэх МХХ-ийн epg.ulaanbaatar.mn цахим программд нэвтрэх эрх үүсгэсэн.

Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 29, НМХГ-ын даргын зөвлөлийн хурал 2, МХЕГ-ын цахим хурал, Коронавируст халдвар /ковид 19/ цар тахлын хариу арга хэмжээний 3 хоногийн дадлага сургуулилтын зохион байгуулах үйл ажиллагааны техник хэрэгслийг холбож хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.

Хүрсэн үр дүн: Дотоод сүлжээний холболт болон компьютер, техник хэрэгсэлд шаардлагатай засвар үйлчилгээг тухайн бүр хийж, техникийн хэвийн үйл ажиллагааг хангаснаар байгууллагын ажил хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлсэн.

Санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг чангатгаж, үр дүнг тайлагнах, шилэн дансны бүртгэлийн хөтлөлт, үнэн зөв байдлыг хангаж ажиллана.

1.8 Санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэл үр дүн:

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны төсвийг сар, улирлаар хуваарилан гүйцэтгэлд нь хяналт тавин зориулалтын дагуу зарцуулсан.

Тайлант хугацаанд нийт цалинд 2,544,754,361.61 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 303,788,219.41 төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд

121,210,535.94төгрөг, хангамж бараа материалын зардалд 78,791,451.34 төгрөг, норматив зардалд 15,011,735 төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 4,693,000 төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжинд 31,218,737 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2,707,586 төгрөг, бусад урсгал шилжүүлэг 63,383,000 төгрөг тус тус зарцуулсан.

2020 оны 05-р сарын 31-ний байдлаар хүү, торгуулийн орлого өссөн дүнгээр 1,417,919,465 бөгөөд төлөвлөгөөний биелэлт 131,7 % байна. Мөн лабораторийн шинжилгээний 131,569,770 төгрөгийн орлогыг Төрийн санд төвлөрүүлсэн бөгөөд төлөвлөгөөний биелэлт 105,25 % байна.

2020 оны 05-р сарын 31-ний байдлаар хэвлэмэл хуудас болон үнэт цаас, бусад хангамжийн 16,002,305 төгрөгийн орлогыг, 9,638,950 төгрөгийн зарлагын журналыг холбогдох хууль дүрмийн дагуу данс бүртгэлд бүртгэж, сар бүр нярвын боловсруулсан тайланг хянаж үлдэгдлийг баталгаажуулсан. МХЕГ-аас мах, махан бүтээгдэхүүний гэрчилгээ 500 ширхэг, амьтны /ЭМГ/ нохой муурны гэрчилгээ 700 ширхэг, импортын мэдэгдэл-500, үнэт цаас -1599 ширхэгийг тус тус хүлээн авсан бөгөөд тус хугацаанд мах махан бүтээгдэхүүний гэрчилгээ 200 ширхэг, амьтаны /ЭМГ/ нохой муурны гэрчилгээ 100 ширхэг, тоног төхөөрөмжийн гэрчилгээ-20 ширхэг, импортын гэрчилгээ - 844 ширхэг тус тус зарцуулагдаж, 4,5-р сард улсын төсөвт гэрчилгээний үнэ болох 4750.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нийт 81 нэр төрлийн 24,298,022 төгрөгийн бичиг хэргийн материал, 166 нэр төрлийн 150,248,339 төгрөгийн аж ахуйн материал, 13 нэр төрлийн 12,996,396 төгрөгийн бусад хангамжийн материал худалдан авч нийт 570 нэр төрлийн 36,519,795 төгрөгийн бичиг хэрэг, 182 нэр төрлийн 83,109,879 төгрөгийн аж ахуйн материалыг албан хаагчдын албан хэрэгцээнд зарцуулан, сар бүр бараа материалын үлдэгдлийг няравтай тулган баталгаажуулж ажиллаж байна.

Хүрсэн үр дүн: Тайлант хугацаанд санхүүгийн сахилга хариуцлага дээшлүүлэхэд анхаарч, батлагдсан төвийн хүрээнд санхүүгийн нөөцийг зөв зохистой зарцуулан, ил тод байдлыг хангасан.

Хяналт шинжилгээ, үнэлгээний талаар:

“Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, УИХ болон Засгийн газрын холбогдох хууль тогтоомж, НИХТХ-ын тогтоол, “Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийлээ.

НМХГ-ын даргын баталсан удирдамжаар Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын хэлтэс, Сүхбаатар дүүрэг дэх МХХ-ийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, НМХГ-ын дэд даргын дэргэдэх Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдэд үндэслэн 10 улсын /ахлах/ байцаагчдад “анхааруулга” өгч, нийт улсын байцаагчдад зөрчил дутагдлыг арилгуулах талаар зөвлөмж хүргүүлэв.

Дотоод хяналт шалгалт мониторингийн хэлтэс нь эхний хагас жилд хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой албан бичиг 42, өргөдөл, гомдол 44-г хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Хүрсэн үр дүн: Хууль тогтоомж, бодлогын баримт бичигт Мэргэжлийн хяналтын байгууллагатай холбоотой тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт хангагдаж, эрчимжсэн.

НМХГ-ын нэгж хэлтсүүд, албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажилласнаар гарсан зөрчил, дутагдлын тоо буурч, хууль тогтоомж, стандарт, нормативын хэрэгжилт сайжирсан.

Хэрэглэгч, бизнес эрхлэгч, улсын байцаагчдын аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд нэгдсэн бодлого, арга зүйн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлнэ.

ХОЁР. БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТАЛААР

2.1 Шилэн хяналтын системийн бүрдүүлэлт:

“Шилэн хяналтын цахим систем”-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг төлөвлөх, явц, гүйцэтгэл, үр дүнг удирдах үйл ажиллагааг системчлэн, статистик мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх, дүн шинжилгээ хийх мэдээллийн суурь баазыг байгуулан ашиглаж байна.

Шилэн хяналтын цахим системд 2019 онд 44851 объектод эрсдэлийн үнэлгээ хийж, 2020 онд 5321 хяналт шалгалт, 2790 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 2268 (42.6%) хяналт шалгалт, 619 (22.2%) зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна.

НМХГ-ын хэмжээнд 448 объектод тандалт судалгаа, 298 объектод хяналт шинжилгээ, 5805 объектод урьдчилсан сэргийлэх шалгалт, 313 объектод хянан баталгаажуулах үйл ажиллагаа, 202 объектод салбарын сургалтыг зохион байгуулж бүртгэсэн байна.

Шилэн хяналтын цахим системд хяналт шалгалтын мэдээллийг бүртгэсэн явцыг сар бүр, улсын байцаагч, хэлтэс бүрээр 6 удаа гаргаж, хэлтэс, улсын байцаагчдад танилцуулж, хугацаатай үүрэг өгч биелэлтийг тооцон ажилласан.

Байгууллагын [/ub.inspection.gov.mn/](http://ub.inspection.gov.mn/) цахим хуудсанд 2020 оны зорилт, төлөвлөлтүүд, явц, биелэлт, эрсдэлийн үнэлгээ, удирдах ажилтан, улсын байцаагчдын ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт, хяналтын хуудас, хэрэглэгчийн хяналтын хуудсыг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, байгууллага, иргэд татан авч, ашиглах, зөвлөгөө мэдээлэл авах хялбар нөхцөлийг бүрдүүлэн байршуулж олон нийтэд хүргэн ашиглаж байна.

Чиглэл болон дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн улсын [/ахлах/](#) байцаагчдад шилэн хяналтын цахим системд мэдээлэл оруулах, гарсан алдааг засахад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.

“Шилэн хяналтын цахим систем ашиглах тухай” улсын /ахлах/ байцаагчдад зориулсан гарын авлага, хэрэглэгчийн хяналтын хуудас ашиглах заавар, бусад хяналтыг бүртгэх видео хичээлийг цахим хуудсанд байршуулан улсын байцаагчид ашиглаж байна. Шилэн хяналтын цахим системд шинээр томилогдсон болон чөлөөлөгдсөн 53 улсын байцаагчдын өөрчлөлтийг хийсэн.

2.2 Хяналтын хуудас, хэрэглэгчийн хяналтын хуудсыг сурталчлах талаар:

Шадар сайдын 2014 оны 87 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн удирдлагын стратеги”-ыг НМХГ-ын цахим хуудас хуудас /ub.inspection.gov.mn/-д байршуулан эрсдэлийн удирдлага, төлөвлөлтийн үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж ажиллаж байна. Улсын /ахлах/ байцаагчид хяналт шалгалтын үеэр аж ахуйн нэгж, байгууллагад очиход, зохион байгуулсан сарын аян, арга хэмжээ, сугалтын үеэр хэрэглэгчийн хяналтын хуудсыг олон нийтэд танилцуулан мөн байгууллагын цахим хуудсанд байршуулан сурталчилж ажиллалаа.

НМХГ-ын цахим хуудас болон иргэдэд үйлчлэх мэдээллийн төвд хяналтын хуудас, хэрэглэгчийн хяналтын хуудсуудыг байршуулан, олон нийтэд тогтмол сурталчилж байна.

2.3 Нийгэмд тулгамдсан тодорхой асуудлаар хэрэглэгчид чиглэсэн аян, мөн нийгэмд болон салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гарцыг олох, төрийн төрийн бус байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор хийсэн хэлэлцүүлэг, уулзалт

Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”, “Зөв дадал-ногоон ирээдүй”, “Хөрсөө хойч үедээ хэвээр нь үлдээе” сэдэвт 3 сарын аянуудыг зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн, хууль тогтоомжийг сурталчилж, болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллалаа.

1.04 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01 өдөр хүртэл “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2020” хүрээнд “Үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэхэд анхаарах асуудал” сэдэвт онлайн сургалт, COVID-19 халдвараас сэргийлэх сэдвээр 2 удаа, НМХГ-ын вэбсайт, ХНХХХ-ийн пейж хуудсаар, /Мэргэжлийн хяналтынхан, Хөдөлмөрийн эрүүл ахуйчид, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналт, Нэн түрүүнд-ХАБ/ facebook группээр дамжуулан Эрсдэлээс урьдчилан сэргийлэх 10 төрлийн мэдэгдэл, 44 зөвлөмж сэрэмжлүүлэг, постер, сурталчилсан.

2. 05 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд “Зөв дадал ногоон ирээдүй” цахим сарын аян зохион байгууллаа. Аяны хүрээнд нийт 16 чиглэлээр 1500 гаруй тараах материал, гарын авлага бэлтгэсэн, агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 13 төрлийн 450 орчим зөвлөмж, сэрэмжлүүлэг, 4 чиглэлээр 1200 ширхэг боршуур, 1 чиглэлээр 300 ширхэг плакат хэвлүүлэн тараалаа. Усны тухай,

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Хог хаягдлын тухай, Химийн хортой бодисын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиуд болон Зуухны стандарт, аюулгүй байдал, Хийн түлшний технологи, Дотоод хяналтын зохион байгуулах Засгийн газрын 311-р тогтоол тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын талаар иргэн аж ахуйн нэгж, байгууллагад зориулсан 9 видео сургалтыг бэлтгэн байгууллагын веб сайт болон олон нийтийн сүлжээнд байршуулсан.

3. 05 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд “Хөрсөө хойч үедээ хэвээр нь үлдээе” сэдэвт сарын аяныг цахим хэлбэрээр зохион байгуулагдсан. Аяны хүрээнд дэд даргын баталсан хөтөлбөрийн хүрээнд улсын байцаагчдад зориулсан “Хөрсний үржил шим-аюулгүй байдал” сэдэвт сургалтын 05 дугаар сарын 13-ны өдөр сургалтын танхимд зохион байгууллаа. Сургалтаар хөрсний үржил шимийг хэрхэн тооцоолох, ургамал хамгааллын химийн бодисын хэрэглээ хөрсөнд нөлөөлөх нөлөөлөл зэрэг сэдвээр улсын байцаагчдад мэдээ мэдээлэл өгсөн. Мөн байгууллага болон дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн цахим хуудас, нүүр номонд хөрс хамгаалах, зүй зохистой ашиглах, цөлжилтөөс сэргийлэх, хөрсний бохирдлын бууруулах, тариалангийн хөрсийг зөв технологээр боловсруулах зэрэг сэдвийн хүрээнд нийт 15 мэдээ мэдээллийг байршуулж ажиллалаа.

2.4. Хяналт шалгалтын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх талаар:

“2015-2019 оны Эрсдэлийн үнэлгээ”, 2019 оны хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, төлөвлөгөөт бус хяналт шалгалт, осол, хордлогын мэдээлэл, гүйцэтгэлийн үр дүн, бусад хяналтын гүйцэтгэлд тус тус дүн шинжилгээнүүдийг хийж цаашид анхаарах асуудал, зөвлөмжийг боловсруулан гаргаж, улсын байцаагч, удирдах ажилтнуудын албан хэрэгцээнд цахимаар хүргүүлсэн.

НМХГ-ын дэд даргын зөвлөлийн хурлаар хяналт шалгалтын явцыг, Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар гүйцэтгэл, үр дүнг хэлэлцэн, үнэлгээ дүгнэлт өгч, шийдвэр гарган, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

ГУРАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлнэ.

ТӨЛӨВЛӨГӨӨТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

3.1. ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, СОЁЛЫН ХЯНАЛТААР:

3.1.1 Эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр:

3.1.1.1 “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт хийх тухай” 02-01/92 тоот удирдамжийн хүрээнд нийт 48 эмнэлэг хяналт шалгалтад хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар 38 буюу (79%) нь хамрагдаж, 4 (10.5%) нь их, 6 (15.8%) нь

дунд, 28 (73.7%) нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар 11 эмнэлэгт 86 заалт бүхий улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 2 эмнэлэгт 2.000.000 төгрөгийн торгууль оногдуулан барагдуулсан. Мөн 1 эмнэлэгийн эмийн санд найруулан бэлтгэсэн 2 нэрийн эмнээс дээж авч лабораторит шинжлүүлэн чанарын шаардлага хангасан тухай 1 дүгнэлт үйлдэж, 1 эмнэлэгийн яаралтай тусламжийн шүүгээнд хадгалагдаж байсан 2 нэрийн 4 ширхэг тарилгын эмийг хураасан.

3.1.1.2 “Эм хангамжийн байгууллагуудад хяналт шалгалт хийх тухай” 02-01/109 тоот удирдамжийн хүрээнд нийт 58 эм ханган нийлүүлэх байгууллагыг хяналт шалгалтад хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар 3 буюу (3.2%) нь их, 13 (22,4%) нь дунд, 42 (72,4%) нь бага, 3 эмийн үйлдвэрээс 1 (33.3%) нь дунд, 2 (66,7%) нь бага эрсдэлтэй үнэлэгдэж. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар 21 байгууллагад 137 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, 10 эм ханган нийлүүлэх байгууллага, 1 эмийн үйлдвэрт нийт 9.500.000 төгрөгийн торгууль, 4 байгууллагад 338300 төгрөгийн шийтгэлийг оногдуулж, албан даалгавар хүргүүлсэн байна. Мөн Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, хаяг шошгын зөрчилтэй 16 нэрийн 3141 ширхэг, 3.687.300 төгрөгийн эмийг 4 байгууллагаас хураан авч, устгуулахаар зөвлөлд шилжүүлэн ажиллалаа.

Хүрсэн үр дүн: 2020 онд шалгахаар зарлагдсан эмнэлэгээс 38 (79%), эм хангамжийн байгууллагуудаас 61(55.2%) эм хангамжийн байгууллагуудыг шалгалтад хамруулаад байна. Шалгалтын хугацаа дуусаагүй, явц 67.1%-тай үргэлжилж байгаа тул үр дүнг тооцох боломжгүй байна.

3.1.2 Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр:

2020 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах эрүүл мэндийн 203 байгууллагаас хяналт шалгалтад хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар 163 буюу (80.3%)-ийг хамрагдаж, 5(3.1%) нь их, 85(53.4%) нь дунд, 69(43.4%) нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Нийт 742 зөрчлийг илрүүлж 440(59.3%)-ийг газар дээр нь арилгуулж, 61 эмнэлэгт 374 заалт бүхий улсын/ ахлах/ байцаагчдын хамтарсан албан шаардлага хүргүүлж, нийт 32 байгууллага, иргэнд 47.025 сая төгрөгийн шийтгэлийг оногдуулан барагдуулж, 25381.5 мян төгрөгийн нөхөн төлбөр тогтоож 20461.5 мян төгрөгийг барагдуулан ажиллаа.

Хүрсэн үр дүн: Эрүүл мэндийн байгууллагуудаас 163 (80.3%)-ыг хяналт шалгалтад хамруулаад байна. Шалгалтын хугацаа дуусаагүй, явц 81%-тай үргэлжилж байна.

3.1.3 Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуйн хяналтаар:

Цаг үеийн шаардлагаар хяналт шалгалт хийгдээгүй

3.1.4 Халдвар судлалын хяналтаар

3.1.4.1 Эрүүл мэндийн 129 байгууллагаас хяналт шалгалтад хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар 108(81,4%)-ийг хамрагдаж, 3 буюу (2.8%) нь их, 47(44.7%) нь дунд, 50(47.6%) нь бага эрсдэлтэй үнэлэгдлээ. Шалгалтаар эрүүл зүйн нян судлалын

шинжилгээтэй хяналтыг 59 (56%)-ийг эмнэлгийг хамруулан, арчдасны 430, агаарын 178, ариун материалын 151, ундны усны шинжилгээнд химийн 30, нян судлалын 30, эмчилгээний хоолны 24 дээжийг 20 эмнэлэгээс авч шинжлүүлсэн. Шалгалтаар нийт 748 зөрчил илрүүлэн 588(78,6%)-ыг газар дээр нь арилгуулж, 54 эмнэлэгт 432 заалт бүхий улсын байцаагчдын хамтарсан албан шаардлага хүргүүлж, нийт 19 байгууллага, иргэнд 11.1 сая төгрөгийн шийтгэлийг оногдуулан барагдуулсан.

Хүрсэн үр дүн: Эрүүл мэндийн байгууллагуудаас 108(81.4%)-ыг хяналт шалгалтад хамруулаад байна. Шалгалтын хугацаа дуусаагүй, явц 82%-тай үргэлжилж байна.

3.1.4.2. Эм хангамжийн 66 байгууллагаас хяналт шалгалтад хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар 29(44%) хамрагдаж, 2 буюу (7%) нь их, 16(55%) нь дунд, 11(38%) нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Нийт 220 зөрчил илрүүлэн 188(85%) зөрчлийг шалгалтын явцад арилгуулж, 7 байгууллагад албан шаардлага, 4 байгууллагад 3000.0 мянган төгрөгийн шийтгэл оногдуулж, барагдууллаа. Эрүүл зүйн нян судлалын шинжилгээнд 2 эмийн үйлдвэрийг хамруулж, 27 арчдас, 15 агаарын дээж, ундны усны шинжилгээнд 5 дээж авч Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Төв лабораторит шинжлүүлж байна. Шалгалтын явц 43%-тай үргэлжилж байна.

Хүрсэн үр дүн: Эм хангамжийн байгууллагуудаас 29(44%)-ийг хяналт шалгалтад хамруулаад байна. Шалгалтын хугацаа дуусаагүй, явц 44%-тай үргэлжилж байна

3.1.5 Орчны эрүүл ахуйн хяналтаар

3.1.5.1. Зочид буудал, дэн буудлын газруудад төлөвлөгөөт шалгалт хийх удирдамжийн хүрээнд нийт 69 зочид буудал, 36 дэн буудал шалгах аар зарласнаас 62 аж ахуйн нэгж шалгалтад хамрагдаж 43 аж ахуйн нэгж тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаа зогсоосон, үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, коронавируст халдварын улмаас үйл ажиллагааг түр зогсоосон тул шалгалтад хамрагдаагүй. Хяналтын хуудсаар 7 буюу(11.2%) нь их, 46 (74.3%) нь дунд, 9(14.5%) нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Шалгалтын эрүүл зүйн нян судлалын шинжилгээнд 136 арчдас, унд ахуйн усны чанар, аюулгүй байдалд үнэлгээ өгөх зорилгоор усны 35 дээж авч хими, нян судлалын үзүүлэлтээр шинжилгээ хийлгэж, нийт улсын байцаагчийн нийт 24 дүгнэлт гаргаж хүргүүлсэн. Шалгалтын явцад 282 зөрчил илрүүлэн 262 заалттай 33 албан шаардлага, эрх бүхий албан тушаалтны 14 албан даалгавраар хугацаатай үүрэг өгч, нийт 14 аж ахуйн нэгж, иргэнд 5350.0 мянган төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ ногдуулсан.

Хүрсэн үр дүн: Хяналт шалгалтын явц 60% -тай шалгалт үргэлжилж байна.

3.1.5.2. “Гоо сайхны бараа, бүтээгдэхүүний үйлдвэр, худалдааны газруудад хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд нийт 8 объект хяналт шалгалт хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар 5 буюу (71%) нь дунд, 2(29%) нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Шалгалтын явцад нийт 18 зөрчлийг илрүүлэн, зөрчлийг

арилгуулах улсын байцаагчийн 5 албан шаардлагахүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.Шалгалт үргэлжилж байна.

Хүрсэн үр дүн:Хяналт шалгалтад хамрагдсан объектуудын хууль сахин мөрдөлтийн түвшин 66%-тай байна.

3.1.6 Хүнсний эрүүл ахуйн хяналтын чиглэлээр

3.1.6.1 “Хүнсний худалдааны газруудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнднийт 226 объект хяналт шалгалтад хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар 209 буюу (92.5%)ньхамрагдаж, 12 (5.7%) хувь нь их, 157 (75.1%) нь дунд, 40 (19.1%) нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн.Шалгалтын явцад нийт 1056 зөрчил илрүүлж, 921 (87.2%)-ийг арилгуулж, 60 аж ахуйн нэгж, иргэнд 523 заалттай улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж,40 аж ахуйн нэгж, иргэнд 21.8сая төгрөгийн шийтгэл оногдуулан бүрэн барагдуулсан.Шалгалтын явцад эрүүл зүйн арчдас шинжилгээ 30, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс 46 сорьц авч шинжлүүлэн, шинжилгээний дүнг үндэслэн 36 улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлт үйлдсэн.

Шалгалтад хамрагдсан хүнсний худалдааны газруудад илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдэлийг бууруулах зорилгоор нийт 5 худалдааны газрын 12 ажиллагсадыг хамруулсан байгууллагын сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгч ажилласан.

Хүрсэн үр дүн:Хүнсний худалдааны газраас209(92,5%)-ыг хяналт шалгалтад хамруулаад байна. Шалгалтын хугацаа дуусаагүй, явц 90%-тай үргэлжилж байна.

3.1.6.2.“Хоол үйлдвэрлэлийн газруудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд нийт187 объект хяналт шалгалт хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар 153(81.8%)нь хамрагдаж, 27 (17.6%) бага, 115 (75.1%) нь дунд, 11 (7.1%) нь их эрсдэлтэй үнэлэгдсэн. Шалгалтаар нийт 923 зөрчил илрүүлэн 588(78,6%)-г газар дээр нь арилгуулж, 28 аж ахуйн нэгж, иргэнд252 заалт бүхий улсын байцаагчдын хамтарсан албан шаардлага хүргүүлж, нийт 33 байгууллага, иргэнд 14.650 сая төгрөгийн шийтгэлийг оногдуулан барагдуулсан.Шалгалтын явцад эрүүл зүйн арчдас шинжилгээ 30, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс 46 сорьц авч шинжлүүлэн, шинжилгээний дүнг үндэслэн 36 улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлт үйлдсэн.

Хүрсэн үр дүн:Хоол үйлдвэрлэлийн газраас153(81.8%)-ыг хяналт шалгалтад хамруулаад байна. Шалгалтын хугацаа дуусаагүй, явц 82 %-тай үргэлжилж байна.

3.1.6.3. НМХГ-ын даргын баталсан 2020 оны 02-01/107 дугаартай удирдамжийн хүрээнд “Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр нийт 48 үйлдвэр хяналт шалгалт хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар 28(58.3%) нь хамрагдаж,7 буюу (25%) нь их, 14(50%) ньдунд, 7(25%) нь бага эрсдэлтэйүнэлэгдсэн.Шалгалтаар нийт 84 зөрчил илрүүлэн, 46 (54.7%)-ийг газар дээр нь арилгуулж, 7 аж ахуй нэгжид 73 заалттай

албаншаардлага, 4 аж ахуй нэгжид албан даалгавар хүргүүлж, 2.1 сая төгрөгийн шийтгэл оногдуулан барагдуулсан. Шалгалтын явцад гүний худаг, технологийн усны 7, бэлэн бүтээгдэхүүний 72 дээж авч шинжилгээнд хамрууллаа. Чингэлтэй дүүргийн Тайванзул ХХК-ийн пүнтүүз нянгийн бохирдолттой, чийг стандартаас зөрүүтэй шинжлэгдсэн бөгөөд Тайван зул ХХК-д Зөрчлийн хэрэг нээж нянгийн бохирдолттой 300.000 төгрөгийн пүнтүүзийг хурааж устгах арга хэмжээг авав. Хяналт шалгалт үргэлжилж байна.

Хүрсэн үр дүн: Хяналт шалгалтын явц 58.3%-тай байна.

3.1.6.4. “Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд шалгалт хийх тухай” 02-01/142 дугаартай удирдамжийн хүрээнд нийт 30 үйлдвэр хяналт шалгалт хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар 6 буюу (20%) нь хамрагдаж, 1(16,7%) нь бага, 5(83.3%) дунд эрсдэлтэй үнэлэгдсэн байна. Шалгалтын явцад цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үр дүнд үнэлгээ өгөхөөр эрүүл зүйн арчдас шинжилгээ 10 цэгээс авахад 2(20%) нь нянгийн бохирдолт илэрсэн. Хөндлөнгийн хяналтаар 4 үндны усны дээжийг шинжилгээнд хамруулсан. Шалгалтаар нийт 32 зөрчил илрүүлэн, 16(50%)-ийг газар дээр нь арилгуулж, 2 аж ахуйн нэгж, иргэнд 45 заалттай албан шаардлага хүргүүлж, 1.3 сая төгрөгийн шийтгэл оногдуулан барагдуулсан.

Хүрсэн үр дүн: Хяналт шалгалт 20 хувьтай үргэлжилж байна.

3.1.7 Боловсролын хяналтын чиглэлээр:

Цаг үеийн шаардлагаар төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй.

3.1.8 Соёлын хяналтын чиглэлээр:

“Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт, соёлын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” 02-01/140 тоот удирдамжийн хүрээнд нийт 11 байгууллага хяналт шалгалт хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар 5 байгууллага дунд, 6 байгууллага бага эрсдэлтэй үнэлэгдлээ. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 8 байгууллагад 69 заалт бүхий улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлж ажиллалаа. Хяналт шалгалтын танилцуулгыг нэгтгэж байна.

Хүрсэн үр дүн: Хууль сахин мөрдөлтийн түвшинг гүйцэтгэлийн хяналтаар 5 хүртэл пунктээр нэмэгдүүлж, шалгалтад хамрагдсан объектод их, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувийг 2 хүртэл пунктээр бууруулан зөрчил арилгуулалтын түвшинг 4,1 пунктээр нэмэгдүүлсэн.

3.2. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

3.2.1 Хүнсний үйлдвэрүүдэд хийсэн хяналт шалгалт:

3.2.1.1 “Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай 02-01/142 тоот удирдамжийн дагуу нийт 118 үйлдвэр хяналт шалгалт хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар 65(55.1%)-ийг хамрагдаж, 4(6.2%) их, 43(66.2%) дунд, 9 (13.8%) бага эрсдэлтэй үнэлэгдсэн ба 9 (13.8%) үйл ажиллагаа нь

зогссон чиглэлээ өөрчилсөн байна. Зөрчил гаргасан 7 хуулийн этгээдэд 6 сая төгрөгийн торгууль ногдуулж, 93 заалт бүхий 14 албан шаардлага, 7 албан даалгавар хүргүүлсэн.

Хүрсэн үр дүн: Хууль сахин мөрдөлтийн түвшинг 58%, Нийт 175 зөрчлөөс 124(70.9 %)-ийг нь арилгуулсан. Гүйцэтгэлийн шалгалтыг албан шаардлага хүргүүлсэн 14, албан даалгавар өгсөн 7 объектод хийнэ.Хугацаа болоогүй байна.

3.2.1.2 “Хүнсний үйлдвэрүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 02-01/107 тоот удирдамжийн хүрээнд нийт 83үйлдвэр хяналт шалгалт хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар55(66.3%)-ыг хамрагдаж, 9(16.4%)их, 25(45.5%) дунд, 10(18.2%)бага эрсдэлтэй үнэлэгдсэн ба 11(20%)үйл ажиллагаа нь зогссон чиглэлээ өөрчилсөн байна. Зөрчил гаргасан 5 хүнд 1.3 сая төгрөг, 5 хуулийн этгээдэд 6.5 сая төгрөг нийт 7.8 сая төгрөгийн шийтгэл ногдуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар 133 заалт бүхий 14 албан шаардлага, зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар 10 албан даалгавар хүргүүлэн ажилласан. БГД-ийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэгч Иргэн Э.Ганбаатарын хэрчсэн гурилын цех “их” эрсдэлтэй үнэлэгдсэн тул тус дүүргийн Прокурорын газрын 10 дугаартай тогтоолоор үйл ажиллагааг түр зогсоож, стандартын шаардлага хангасан байранд /ЧД-т/ нүүлгэн шилжүүлсэн.

Хүрсэн үр дүн: Хамрагдсан үйлдвэрүүдийн хэмжээнд хууль сахин мөрдөлтийг 63%.Нийт 218 зөрчил илэрснээс 162 (74.3%) арилгуулсан. Гүйцэтгэлийн шалгалтыг албан шаардлага хүргүүлсэн 14, албан даалгавар өгсөн 10 объектод хийнэ. Хугацаа болоогүй байна.

3.2.2 Худалдааны газруудад хийсэн хяналт шалгалт:

Төлөвлөгөөт хяналт шалгалтад нийт392 хүнсний худалдааны газраас хяналт шалгалт хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар369 (94.1%) хамрагдаж, 8(2.1%) их, 258 (69.9%) дунд, 102(27.7%) бага эрсдэлтэй үнэлэгдлээ. Нийт 1034 зөрчил илрүүлж 808(78.1%)-ийг арилгуулав. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 916 заалт бүрий124 албан шаардлага, 30 албан даалгавар хүргүүлсэн. Шалгалтаар 49 хуулийн этгээд, хувь хүнд 33.000.0 төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулсан. Чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй, муудсан, хадгалалтын хугацаа дууссан 6 нэр төрлийн 2418 ширхэг, 421.200 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг 7 хураах акт тогтоон, “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах” зөвлөлд шилжүүлсэн байна. Хаяг шошгын шаардлага хангаагүй 3 нэр төрлийн, 248.300 төгрөгийн хүнсний хүнсний сүлжээнээс татан авалт хийлгүүлж, зөрчлийг арилгуулсан.

Хүрсэн үр дүн:Хууль сахин мөрдөлтийн түвшин өмнөх оны мөн үед 70.4%-тай байсан бол 2020 онд 63.5 (7%) буурсан, албан шаардлага, албан даалгаврын биелэлт 78.8%-тай байсан бол 2020 онд 88.6 (7.4%)нэмэгдүүлж, торгуулийн

барагдуулалт (93.6%) байна. Их эрсдэлтэй объектын эзлэх хувийг 32 (20%)-оор бууруулж, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувь 53.6 (12.8%) нэмэгдсэн байна.

3.2.3 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад хийсэн хяналт шалгалт:

Төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр зарлагдсан нийт 313байгууллага хяналт шалгалт хамрагдахаас эхний хагас жилийн байдлаар233(75%)-ыг хамрагдаж, 30(13%) их,168 (72%) дунд, 35(15%) бага эрсдэлтэй үнэлэгдлээ.

2. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын баталсан 02-03/08 тоот удирдамжийн хүрээнд Сүхбаатар дүүргийн 11, 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт барилгын материалын худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж буй 161 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж хяналт шалгалт хийлээ.Шалгалтад газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрээ, гэрчилгээнд заасан зориулалтын дагуу газраа ашиглахгүй барилгын материалын худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэж байгаа өмчилсөн 132, эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээтэй 27, ашиглах эрхийн гэрчилгээтэй 2 иргэний газар ашиглалтын байдлыг шалгажарга хэмжээ авах талаар 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 02-01/2277 дугаартай албан бичгийг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлсэн.

3.Нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн “Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Олон Улсын хүүхдийн Найрамдал зуслангийн орчинд шалгалт хийж, дүгнэлт гарган арга хэмжээ авах тухай” албан бичгийн дагуу НМХГ-ын даргын баталсан 02-03/411 тоот удирдамжийн хүрээнд нийслэлийн тусгай хамгаалалттай Баянголын байгалийн цогцолбор газарт байрлах Олон улсын хүүхдийн “Найрамдал” төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, газар ашиглалтын байдалд хяналт шалгалт хийлээ.Шалгалтад 62 иргэн хамруулж зөрчил гаргасан иргэнд арга хэмжээ авах тухай 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 02-03/497 дугаартай албан бичгийг Нийслэлийн Засаг даргад хүргүүлсэн.

4. Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/513 дугаар “Газрын зөрчил арилгах, орчны аюулгүй байдлыг хангах, дугуйн замын трассыг чөлөөлөх талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамжаар нийслэлийн нутаг дэвсгэрт 13 байршилд орц гарц гаргаж чөлөөлсөн, нийтийн эзэмшлийн газарт зөвшөөрөлгүй баригдсан 69 авто машины гараж, чингэлгийг буулгаж чөлөөлсөн байна.

5. НМХГ-ын дэд даргын баталсан 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 02-02/148 тоот “Арьс шир, ноос ноолуурын үйлдвэрлэл эрхлэгч ААН-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу арьс ширний 62, ноос ноолуурын 50 ААНБ-д хяналт шалгалт хийснээсүйлажиллагаа явуулаагүй 56, үйл ажиллагаа хэвийн явуулж байгаа 56 байгууллага байна.

Мөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хаягдал усны эзлэхүүнийг тодорхойлох хэмжиххэрэгсэл /тоолуур/ суурилуулалтыг шалгахад бохир усны гаргалгаан дээр хаягдал усны эзлэхүүнийг тодорхойлох хэмжиххэрэгсэл /тоолуур/ суурилуулаагүй байна. Мөн 5 ААНБ үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөөгүй зөрчил илэрсэн тул тус бүрд нь 1500.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч зөрчлийн үр дагаврыг арилгах талаар албан даалгавар хүргүүлээд байна. Шалгалтанд хамрагдсан 3 ААНБ нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажиллаж байсан тул 1500.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 1 ААНБ нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлага биелүүлээгүй тул 3000.0 мянган төгрөгийн арга хэмжээ авч ажиллалаа.Хяналт шалгалттай холбогдуулан хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч 8 аж ахуйн нэгжээс бохир уснаас шинжилгээ авч шинжилгээний дүгнэлт гаргасан.

6. Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар, Ашигт малтмал, Газрын тосны газартай хамтран нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 221 ШТС, 55 АХЦС-уудын шатахуун болон шингэрүүлсэн шатдаг хий хадгалах савнуудын бүртгэлжилтийг шинэчлэн гаргасан, улсын бүртгэлд хамрагдаагүй савны тоог гаргаж бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулсан.

7. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газартай хамтран 12 ААН-ийн шатахуун түгээх станц, 1 ААН-ийн газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах, шатахууны түгээгүүрийн шахалтын хэмжээг газар дээр нь шалгаж, бүтээгдэхүүнээс дээж авч ажиллалаа.3 ААН-ийн худалдаалагдаж байсан дизель түлш, шатахууны бүтээгдэхүүнээс дээж авч Ашигт малтмал, газрын тосны газрын итгэмжлэгдсэн Лабораторид хүргүүлээд байна.

Агаарын чанарын хяналтын чиглэлээр:

8. Засгийн газрын 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1016 дугаартай захирамжийн дагуу 273 албан хаагч 24 цагаар шуурхай штабад ажиллах явцдаа 351 өрхийн 1028 иргэний угаарын хийд өртсөн гэсэн дуудлагын дагуу халаалтын зуух, шахмал түлш ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, Таван толгой түлш ХХК, шахмал түлшний борлуулалтын цэгтүүдэд хяналт тавьж ажилласан.

9. НМХГ-ын дэд даргын баталсан 2020 оны 01 сарын 03-ны өдрийн 02-03/06 дугаартай “Агаар бохирдуулагч эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд 100 кВт-с дээш хүчин

чадалтай агаар бохирдуулагч эх үүсвэр ашиглагч 119 аж ахуйн нэгж байгууллагын 155 халаалтын зуух ашиглалтын байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтын явцад нийт 20 зөрчил илрүүлэн, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 20 аж ахуйн нэгж байгууллагад 27900.0 мян төгрөгийн торгууль ногдуулан барагдууллаа.

Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр:

10. Нийтийн тээврийн компаниудад хийгдсэн 6 удаагийн хяналт шалгалтаар хот доторх нийтийн тээвэр үйлчилгээний 487 автобусны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн байдалд хяналт тавьхад шаардлага хангасан 335 автобус байсан ба шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг бүрэн арилгаагүй, тээвэрлэгчийн үүргээ биелүүлээгүй “Эрдэм транс” ХХК-д хугацаатай үүрэг даалгавар өгч, дутагдлыг арилгуулсан.

11. Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт 5889 худалдаа, үйлчилгээний байгууллагуудын үйлчлүүлэгчдэд зориулж бие засах, гар угаах нөхцөлийг бүрдүүлсэн байдалд хяналт тавихад 3465 нь бие засах, гар угаах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Шалгалтын явцад мэргэжлийн байгуулагаас гаргасан зөвлөмж сэрэмжлүүлэг, мэдэгдлийг хүргүүлэн, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч ажилласан. Үйлчилгээний ажилтнууд маск зүүгээгүй хүнсний худалдааны газар 32, гар халдваргүйтгэх бодисгүй 30 хүнсний дэлгүүр, 8 цайны газарт зөвлөгөө өгч, хог хаягдал ихтэй, цэвэрлэгээ, халдваргүйтгэл хангалтгүй, хийдэггүй орчинд үйл ажиллагаа явуулж байсан зөрчилд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 2 иргэнд тус бүр 50 нэгжтэй тэнцэх хэмжээний торгуулийн арга хэмжээ ногдуулж, зөрчлийг арилгуулсан.

12. Бүх чиглэлийн хяналт шалгалтын явцад нийт 6289 объектод гадна орчны 50 м хүртэлх газрын хог хаягдал, цас мөсийг цэвэрлэсэн эсэхэд хяналт тавихад 6185 объект шаардлага хангасан байв. Өөрийн эдэлбэр газар болон түүнээс 50 метр хүртлэх хог хаягдал, цас мөсийг цэвэрлэх тухай мэдэгдэх хуудсыг 4592 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад, улсын /ахлах/ байцаагчийн хугацаатай албан шаардлагыг 16 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлж, улсын байцаагчийн тавьсан шаардлага биелүүлээгүй, орчныхоо 50 м хүртэлх газрын цас, мөс, хог хаягдлыг цэвэрлэгээний байдалд хяналт хийхэд орчны хог хаягдлыг цэвэрлээгүй, хог хаягдлаа зориулалтын бус газар хаясан, хогын сав, цэг нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй байсан 18 аж ахуйн нэгжид 6450.0 мян.төгрөгийн торгуулийн шийтгэл ногдуулж, зөрчлийг арилгуулсан.

Эмчилгээний хяналтын чиглэлээр:

13. НМХГ-ын дэд даргын 2019 оны 12 дүгээр сарын 23-ны өдөр баталсан “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд АШУИС, Лизаров, Юнимед эмнэлгүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Тус эмнэлгүүдийн рентген оношилгооны цацрагийн аюулгүй ажиллагааны эрсдэлийг 10.2 кодтой “Рентген оношилгооны цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар үнэлэхэд нийт 15 зөрчлийг илрүүлж, бүгд бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Шалгалтаар 1

эмнэлэгт 7 заалттай улсын байцаагчийн албан шаардлага, АШУИС-ийн нэгдсэн эмнэлэг, Лизаров эмнэлгүүдэд зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, Лизаров эмнэлгийн зөрчил гаргасан хүнд 300,000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, рентген аппаратын ашиглалтын үйл ажиллагааг 3 сараар түр зогсоосон.

14. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын баталсан 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02-02/34 дугаартай удирдамжийн хүрээнд нийт 50 эмнэлэгт / төв эмнэлэг 3, төрөлжсөн мэргэжлийн 4 эмнэлэг, 3 амаржих газар, 8 дүүргийн Эрүүл мэндийн төв, нийт 18 Өрхийн эрүүл мэндийн төвд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, нэг удаагийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг нэмэгдүүлж ажилласан.

Эм био бэлдмэлийн хяналтын чиглэлээр:

15.МХЕГ-ын дэд дарга, ЭМЯ-ны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нарын хамтран баталсан удирдамжийн дагуу 5 ААН-ийн эмийн үйлдвэрүүд, 1 ААН-ийн гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрт төлөвлөгөөт бус хяналт хийж, спиртэнд суурилсан гар халдваргүйжүүлэх уусмалын чанар аюулгүй байдлыг шалгалаа. Шалгалтаар илэрсэн зөрчлийг нүдэслэн 1 байгууллагыг 300,00 төгрөгөөр торгож, 2 байгууллагад албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч ажилласан

Халдвар судлалын хяналтын чиглэлээр:

16. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын баталсан 02-02/61 дугаартай удирдамжийн хүрээнд 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс 02 дугаар сарын 27-ны өдрүүдэд Ахуйн хортон шавж, мэрэгч устгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ эрхлэгч 37 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан, халдваргүйжүүлэлтэд хэрэглэж байсан клорсепт 17, 25, жавелион нэрийн химийн бодис болон ажлын уусмалаас нийт 65 дээж авч, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Төв лабораторид шинжлүүлэн, шинжилгээний хариуг үндэслэн 30 дүгнэлт бичиж хүргүүлсэн.

17. Ахуйн хортон шавж, мэрэгч устгал, халдвар гүйтгэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусгавар болсон, мэргэжлийн мэргэшсэн боловсон хүчний нөөцгүй, чадамжгүй болсон Эмбиди ХХК-ийн үйл ажиллагааг түтгэлзүүлэх саналыг Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлэн ажилласан. Химийн бодис ашиглах журам зөрчсөн Өгөөш ХХК-д 3 сая төгрөгийн шийтгэвэр ногдуулан барагдуулан ажилласан.

Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын чиглэлээр:

18. Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2020.01.28-ны өдрийн “Нийслэлийн хүн амын 2020 оны хаврын улирлын махны хэрэгцээнд зориулан бэлтгэсэн махны нөөц бүрдүүлэлт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын хэвийн үйл ажиллагааг хангуулах, хяналт тавих ажлын удирдамж”-ийн

хүрээнд 2020 оны хаврын махны хангамж үнийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд арилжааныбанк, өөрийн хөрөнгө, бодлогын гэрээ, хөдөө аж ахуйн бирж зэрэг дөрвөн эх үүсвэрээр 15 аж ахуйн нэгж нийт 13 мянган тонн махыг бэлтгэн нөөцлөх, хадгалалт, тээвэрлэлт, жижиглэн савлалт, 9 дүүргийн 394 хүнсний дэлгүүр, өргөтгөсөн худалдааны 24 цэгээр худалдан борлуулах явцад 2020 оны 2 дугаар сарын 03-наас 6 дугаар сарын 10-ны өдрийн хүртэл 18 удаагийн хяналт шалгалтыг хийлээ.

19.Шалгалтын явцад Нөөцийн мах бэлтгэн нийлүүлсэн 38 аж ахуйн нэгжийн бэлтгэсэн махнаас чанар аюулгүй байдалд үнэлэлт өгөх зорилгоор түүвэрчилсэн дээж авч УМЭАЦТЛ-т малын эмийн үлдэгдэл, хүнд металл, нян судлалын шинжилгээ хийлгэж, чанар аюулгүй байдлын шаардлага хангасан тухай улсын /ахлах/ байцаагчийн 38 дүгнэлт гаргалаа.Эхний хагас жилийн байдлаар 12469 тонн нөөцийн мах нийлүүлэхээс 7126.0 тонн буюу 57.14 %-ыг борлуулсан байна.

20.Нийслэлийн хэмжээнд 405212 м2 хашаа, хороо, өтөг бууц, худаг уст цэг, малын гаралтай түүхий эд хадгалдаг агуулах үйлдвэр, худалдааны төвийн 54756м2 талбай, бэлчээрийн талбай 53932 м2, сэг зэм устгалын цэг, хогийн цэгийн 85102 м2, авто тээврийн шалган нэвтрүүлэх 7 товчоод, Коронавирус /Ковид-19/ болон бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн талбай 102308 м2 нийт 701310м2 талбайд ариутгал халдваргүйтгэл, Сонгинохайрхан, Хан-Уул, Багахангай, Баянзүрх, Налайх дүүргийн нийт 201818 толгой мал, амьтныг шүлхий өвчнөөс, 21343 бог малыг доторын халдварт хордлого, 8055 толгой гахайг гахайн мялзан, 13587 үхэр боом өвчнөөс, 3768 төлийг шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулсан.

АРВАН НЭГ. ШИНЭ КОРОНАВИРУСААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Үйл ажиллагаа түр зогссон байгууллагуудад хяналт тавьсан байдал:

1. Дэлхий дахинд хурдацтайгаар тархаж буй коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон мэргэжлийн байгууллагуудаас гаргасан тогтоол, захирамж, тушаал, заавар, журмын хэрэгжилтийг хангуулан ажиллахаар тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэх, зарим байгууллагын үйл ажиллагааг түр зогсоох тухай нийт 38 төрлийн мэдэгдэл, 4 төрлийн зөвлөмжийг 17000 гаруй аж ахуй нэгжид хүргүүлж, 388 дэн буудал, 92 саун, бассейн, 117 амралт, жуулчны бааз, 1335 хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар /22:00 цаг хүртэл/, 794 бүх төрлийн баар, 138 бялдаржуулах төв, иога, спорт заал, 287 сүм, хийд, 49 биллъяардны газрын үйл ажиллагааг түр зогсоож, хэрэгжилтэд тогтмол хяналт шалгалт хийгдэж байна.

2. Үйл ажиллагаа түр зогссон болон хязгаарлагдсан цагаар үйл ажиллагаа явуулж байгаа худалдааны газар 1288, ресторан 1914, баар 2233, түргэн хоолны газар 32, кафе 408, нийт 5843 аж ахуйн нэгжид 2 төрлийн мэдэгдэл /22 цаг хүртэл ажиллах, үйл ажиллагааг түр зогсоох тухай/ хүргүүлж, 945 аж ахуйн нэгжид хяналт тавьж ажилласан.

Шөнийн шалгалтыг 103 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 301 улсын /ахлах/ байцаагч хяналт тавьж ажилласан байна. Зөрчилтэй үйл ажиллагаа явуулж байсан 21 аж ахуйн нэгжид 19500.0 мянган төгрөг, 3 иргэнд 790.0 мянган төгрөг, нийт 20290.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулан, 77 заалт бүхий улсын байцаагчийн 6 албан шаардлага, 6 аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлэх саналыг УБЗАА-нд, караоке үйлчилгээ явуулах 1 зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг НСУГ-т тус тус хүргүүлсэн.

3. Нийслэлийн Засаг даргын А/108, А/223 тоот сүм хийд, мөргөлийн газруудын үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг дуустал түр зогсоох, олон нийтийг хамруулсан үйл ажиллагаа зохион байгуулахгүй байх тухай захирамжийн хүрээнд НМХГ-ын даргын 02-01/636, 02-01/772 тоот мэдэгдлийг 396 /давхардсан тоогоор нийт662/ сүм хийдийн удирдлагуудад хүргүүлж хяналт тавин ажилласан. Хяналт шалгалтаар нийслэлийн хэмжээнд 46сүм, хийд зөвшөөрөлгүй холбогдох хуулийн байгууллагад бүртгэгдээгүй хууль бус үйл ажиллагаа явуулж байсан, нэг сүмийн тусгай зөвшөөрөлд 9 салбар сүм байгуулан ажиллаж байсан, зөвшөөрөлд заасан хаяг байршилд үйл ажиллагаа явуулаагүй зэрэг зөрчлийг илрүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээллэн, холбогдох байгууллагуудад цаашид авах арга хэмжээний саналыг хүргүүлсэн.

4. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/590 дугаар захирамжийн дагуу 5-р сарын 1-нээс эхлэн нийслэлийн нутаг дэвсгэрт стандартын шаардлага хангах хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа спорт заал, бассейн, бүжгийн клуб, сургалтын төвийн танхимын сургалтаас бусад сургалтын үйл ажиллагааг нээхээр болсонтой холбогдуулан зөвлөмж, мэдэгдлийг хүргүүлэн нээсэн. Нийслэлийн нутаг дэвсгэрт шаардлага хангах хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа спорт заал 13, нийтийн бүжиг 16, сургалтын 253,саун бассейн 14, дэн буудал 21, биллиард 21 бүх төрлийн баар 25, бялдаржуулах чийрэгжүүлэх клуб 5, шашины 56, сургалтын 45, ресторан, кафе, сүлжээ хоолны газар 18 зэрэггазруудад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллаж байна.

Алтанбулаг хилийн боомтод ажилласан байдал:

5. МХЕГ-ын дарга, Улсын ерөнхий байцаагчийн өгсөн үүргийн дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар болон Алтанбулаг боомтод 4 байцаагч 4 удаа томилогдон ажиллаж, Алтанбулаг боомт дах хилээр нэвтэрч буй нийт 2089 тээврийн хэрэгсэлээр зорчиж ирсэн 4687 зорчигчдын эрүүл мэндийн байдалд тандалт судалгаа хийж, халдварын эрсдэлтэй болон маш өндөр эрсдэлтэй улс орноос ирсэн 23 зорчигчийг тусгаарлан ажиглалтад шилжүүлсэн. Сүхбаатар боомтоор галт тэргээр хил нэвтэрч буй 172 зорчигчийн эрүүл мэндийн байдалд тандалт хийж, халдварын эрсдэл өндөр болон маш өндөр эрсдэлтэй улс орноос ирсэн 61 зорчигчийг ажиглалтад тусгаарлан, гадаадын 26 зорчигчийг буцаасан болно.

“Ковид-19 халдварт цар тахлын үед зохион байгуулсан сургалт:

6. “Ковид-19 халдварт цар тахлын үеийн харилцан ажиллагаа хариу арга хэмжээ” дадлага сургуулилтын байгууллагын болон салбар дундын төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, Нийслэлийн онцгой комисс, НМХГ-ын мэргэжлийн ангиудад эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчид ажиллаж, дадлага сургуулилтын үед мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа. Буянт-Ухаа спортын ордны 4900 м2 талбайд халдварын хөнгөн хэлбэрээр өвчилсөн 300 иргэнийг хүлээж авч, эмчлэх хүчин чадалтай, өвчлөл хүндэрсэн тохиолдолд 200 ор нэмж дэлгэхээр зохицуулалт хийсэн, “Яармаг-300” түр эмнэлэгийг зохион байгуулсан. Ковид-19” цар тахлын үеийн эмнэл зүй, оношлогоо, халдвараас сэргийлэх чиглэлээр ДЭМБ, Мэргэжлийн байгууллагуудаас хийж буй сургалт, зөвлөмж, гарын авлага, материалыг уншиж судлан, эмч мэргэжилтнүүдтэй харилцан мэдээлэл солилцож, дэмжлэгт хяналт тавин, мэргэжил арга зүйгээр ханган, Яармаг-100, Яармаг-300 эмнэлгийн бэлэн байдлыг хангуулан ажилласан.

7. Улсын байцаагчдын ажил үүргийн онцлогоос хамааран хамгаалах хувцас хэрэгслийн зөв хэрэглээ, өмсөж, тайлах дараалал, халдвараас хэрхэн сэргийлэх сэдэвт 3 удаагийн сургалтад 92 байцаагчдыг хамруулсан. .

“Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр ААНБ, иргэнд хүргүүлсэн зөвлөмж, мэдэгдэл:

8. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, амны хаалтны зөв хэрэглээ, ажлын байр, гэрийн нөхцөл дэх цэвэрлэгээ халдваргүйтгэл гэх мэт 2578 төрлийн зөвлөмж, 617 төрлийн сэрэмжлүүлгийг иргэдэд тогтмол хүргэж байна.

9. Байгууллагын 15 тээврийн хэрэгсэлд зурагт зөвлөмжийг байршуулан хяналт шалгалтын явцад хөдөлгөөнт сурталчилгаа хийж, нийслэлийн 52 томоохон зах, худалдааны төвүүдэд өдөр бүр чанга яригчаар зөвлөмж, сэрэмжлүүлгийг иргэдэд түгээж байна. Мөн тээврийн хэрэгслийн 186806 зорчигчдод коронавируст халдвараас сэргийлэх зурагт зөвлөмжийг тараасан.

АРВАН ХОЁР. САНААЧЛАН ХИЙСЭН ҮР ДҮНТЭЙ АЖИЛ:

✓ Хяналт шалгалтын чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор Цөмийн энергийн комиссын Ажлын албанаас цацрагийн хэмжилтийн 3 төрлийн багажийг 2 жилийн хугацаатайгаар гэрээ байгуулж авсан.

✓ Түүхий нүүрсний хэрэглээг хориглосон Засгийн газрын 62 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт шалгалтын талаар видео тайлан бэлтгэн байгууллагын вэб сайт болон цахим сайтад байршуулан олон нийтэд мэдээлэл хүргэсэн.

✓ Барилгачдын талбай, БЗД-ийн 2 байршил, СХД-ийн 2 байршил, ЧД-ийн 10 байршилд, СБД-1 байршлуудаас дроноор агаарын бохирдлын зураглал хийж 2019 оны

өвлийн улиралтай харьцуулан видео бэлтгэн байгууллагын вэб сайтад байршуулан олон нийтэд мэдээллээ.

✓ 2020 оны 03 дугаарсарын 14-ний өдөрИдшидийнорон 2 төвдбарилгабайгууламжийгбайнгынашиглалтадоруулахулсынкомиссодажиллажулмаарт усхүүхдийнтөлөөүйлажиллагааявуулжбайгаатөвд НМХГ-ын ДБХХ-ийнхамтолонбяцханхүүхдүүдэдзориулжбөмбөг,шатар,ширээнийтенниснийхэрэгсэл 200 ширхэггарнүүрнийсаванбэлэглэн,Идшидийнахэгчөргөмжлөлийггээдболсон.

✓ Хүнсний нян судлал, гадаад орчны нян судлалын шинжилгээгээр илэрсэн E.coli өсгөвөрүүдэд E.coli O157 хэв шинжийг тодорхойлох шинжилгээнд шаардлагатай урвалж бодис, тэжээлт орчны үнийн санал авч, 2020 оны Төв лабораторийн тэжээлт орчны захиалгад оруулсан.

✓ L.monocytogenes-ийн ийлдэс судлалын болон багажит шинжилгээг хийхэд шаардлагатай Listeria Latex test болон Ridascreen Listeria зэргийн үнийг судлан, Төв лабораторийн нэгдсэн захиалганд оруулсан. Мөн шинжилгээний арга, аргачлалыг судлан арга зүй боловсруулсан.

✓ Yersinia enterocolitica-г илрүүлэх стандарт, арга, аргачлалыг судлан, шинжилгээнд шаардлагатай тэжээлт орчин, урвалж бодисыг захиалсан.

✓ Үр дүнгийн тооцоолол нь эргэлзээтэй дараах шинжилгээний аргын үр дүн, томъёо, тооцооллыг шалгаж, хяналт хийн ажлын хуудасанд өөрчлөлт оруулсан ба цаашид нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж байна. Үүнд: MNS 5574:2005 Ариутгал халдваргүйтгэлийн бодисны идэвхтэй хлорийн агуулгыг тодорхойлох титрийн арга.

✓ MNS 4273:1995 Ахуйн хэрэглээний цаас “Ариун цэврийн цаас” Техникийн шаардлагын 2.4.3-ын 2 дахь томъёонд өөрчлөлт оруулахаар лабораторийн туршилт хийсэн.

✓ Элсэн чихрийн шинжилгээний арга MNS 1752:1973 стандартад нэмэлт өөрчлөлт оруулах стандартын төслийг боловсруулж СХЗГ-т хүргүүлсэн.

✓ Усанд уусдаг ба хүчилд уусдаг сульфатыг тодорхойлох 24 хуудас бүхий ISO 11048:1995 (EN) аргын стандартыг англи хэлнээс орчуулан гадаадын стандарт хэрэглэх зөвшөөрөл хүссэн албан бичиг СХЗГ-т хүргүүлэн түр хэрэглэх зөвшөөрлийг аван, туршилтыг хийж эхлээд байна.

АРВАН ГУРАВ. ДҮГНЭЛТ, ҮР ДҮН

1. 2020 оныг “Хамтын хяналт, аюулгүй байдал” зорилтот жил болгон зарласантай холбогдуулан мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, иргэд, бизнес эрхлэгчдийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, эрсдэлийг үнэлгээг илүү оновчтой хийх, иргэн, аж ахуйн

нэгж, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, үр дүнгээ тооцон ажиллалаа.

2. 2020 оны эхний хагас жилд НМХГ-ын хэмжээнд 5321 төлөвлөгөөт шалгалт, 2790 төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөснөөс 2268 (42.6%) төлөвлөгөөт шалгалт, 619 (22.2%) зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна. /Хавсралт-1, График 1/

3. 2020 оны эхний хагас жилд улсын байцаагчдын үйлдсэн албан шаардлагаөмнөх оны мөн үетэй харьцуулахад 47.4%-иар, акт 23.3%-иар, дүгнэлт 9.1%-иар, торгуулийн хэмжээ 11.1%-иар, улсын орлого болгосон эд зүйлсийн дүн 2.0 дахин тус тус буурсан бол зөвлөмж 0.7%-иар нөхөн төлбөр 1.6 дахин, хурааж устгасан эд зүйлсийн дүн 24.4%-иартус тус өссөн үзүүлэлттэй байна. /Хавсралт-2, График 4, 5, 7, 8, 9, Хүснэгт 1/

4. Зөрчил гаргасан 56 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, зөрчлөө арилгасан 18 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг сэргээсэн нь өмнөх оноос үйл ажиллагааг түр зогсоосон аж ахуйн нэгжийн тоо 2.1 дахин, үйл ажиллагааг сэргээсэн аж ахуй нэгжийн тоо 1.8 дахин тус тус буурсан байна. /Хавсралт-2, График 6/

5. Хяналтын ажлын үр дүн, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж олон нийтэд хүргэсэн мэдээ мэдээллийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.7 хувиар буурсан байна. /Хавсралт-2, График 12/

6. Иргэн, олон нийт, аж ахуйн нэгжид хүргүүлсэн зөвлөмж, мэдэгдэл өмнөх оныхтой харьцуулахад 10.3%-иар өссөн нь иргэдийг болзошгүй эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ болсон. /Хавсралт-2, График 12,14/

7. Зохион байгуулалтын нэгж, хэлтсүүдийн үйл ажиллагаа, улсын байцаагчдын үйлдсэн баримт бичигт дотоод хяналт шалгалт хийж, гарсан алдааг засуулан, дүгнэлт, зөвлөмж гаргаж ажилласан нь ажлын чанар үр дүн сайжрах нөхцөлийг бүрдүүлсэн.

8. Шилэн хяналтын цахим систем, хэлтэс, нэгжүүдээс ирүүлсэн үйл ажиллагааны мэдээлэлд үндэслэн ажлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийн үнэлэлт өгч, улсын байцаагчдын ажлыг сар, улирал, хагас жилээр дүгнэн хариуцлага тооцон ажилласан нь ажлын гүйцэтгэл сайжрахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн.

9. 2015-2019 оны эрсдэлийн үнэлгээ, 2019 оны төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн, бусад хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний гүйцэтгэл, авсан арга хэмжээ, лабораторийн үйл ажиллагаа, эрсдэлээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажиллагааны үр дүн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн нь эрсдэлийн төлөв байдлыг бодитой тодорхойлох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт шалгалтын үр дүнг сайжруулахад тоон мэдээллийг ашиглах, улмаар улсын байцаагчид өөрийн хариуцсан чиглэлээр дүн шинжилгээ хийж хэвшихэд ач холбогдолтой дүн шинжилгээ болсон.

10. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр олон ажлыг хийж хэрэгжүүлсний дүнд Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын 2019 оны 11 дүгээр сарын дундаж

агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нарийн ширхэглэгт тоос, тоосонцорын хэмжээ 50%-иар багассан байна.

11. Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комисс, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн Онцгой комисс, Нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн сайдын баталсан холбогдох захирамж, тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор тус газрын даргын 2020.02.13-ны өдрийн Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай А/09, 2020.03.27, 2020.04.30-ны өдрийн Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай А/31, А/49, 2020.04.08-ны өдрийн Гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдэд хяналт тавих тухай А/34, 2020.04.29-ний өдрийн Коронавируст халдварт цар тахлын хариу арга хэмжээний дадлага сургуулилтад оролцох тухай А/47 дугаар тушаалууд батлагдан, нийт улсын /ахлах/ байцаагч, албан хаагчид хэрэгжүүлэн, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

АРВАН ДӨРӨВ. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Бодлогын түвшинд зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай хяналт шалгалтын явцад тулгамдаж байгаа асуудлын талаар

- Импортын бодис, бараа бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулсан тохиолдолд шинжилгээний хариу гарах хүртэл хугацаанд түр битүүмжлэн хадгалах стандартын шаардлага хангасан хяналтын байгууллагын агуулахтай болох асуудлыг шийдвэрлэх
- Рентген оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй эмнэлгүүдийн рентген аппаратуудын цацрагийн аюулгүй ажиллагаанд тавих цацрагийн хяналтыг иж бүрэн хийхэд шаардлагатай чанарын хяналтын багажаар хангах
- Нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглагдаж, хадгалагдаж буй цацраг идэвхт үүсгүүр, рентген аппаратын улсын тооллого хийхэд шаардлагатай холбогдох зардлыг шийдвэрлүүлэх /улсын тооллогод оролцох холбогдох төрийн байгууллагуудын албан хаагчдыг цацрагаас хамгаалах хувцас хэрэгслээр хангах, унаа бусад зардал/
- Хөдөө орон нутаг руу иргэд сайжруулсан шахмал түлшийг тээвэрлэн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоогоор гаргахыг завдсан үйлдлийг таслан зогсоож байгаа бөгөөд нийслэлд хэрэглэн хотоос гаргахгүй гэсэн тушаал шийдвэрээ үзүүл гэх мэтээр хүндрэл гарч байгаа тул энэ талаар шийдвэр гаргах.
- Хил, гүний хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн программыг улсын хэмжээнд МХЕГ-аас шинэчлэн боловсруулж, нэгдсэн нэг программаар гаалийн байгууллага болон лабораторийн сүлжээнд холбож, харилцан мэдээлэл солилцож ажиллах, мэдээллийг үнэн зөв солилцох нөхцөлийг бүрдүүлэх;

- Хүнсний үйлдвэрүүдэд үйлдвэрлэлийн /GMP/ зохистой дадал, эрүүл ахуйн /GHP/ зохистой дадал нэвтрүүлсэн эсэхэд үнэлгээ өгөх аргачлал гаргах, сургалтыг үе шаттай зохион байгуулах нь зүйтэй байна.
- Хүнсний бүтээгдэхүүний иж бүрэн судалгаа шинжилгээ хийх лабораторийг бий болгох, амьтны болон ургамлын гаралтай уураг, тосны хүчлийн бүрдэл, химийн болон байгалийн гаралтайг тогтоох шинжилгээг хийдэг, хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын горим, нөхцлийг нарийвчлан судалдаг, хүнсний аюулгүй байдалд судалгаа дүн шинжилгээ хийх, мэдээлэл харилцан солилцдог хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны институтийг байгуулах
 - Хяналт шалгалт хийх чиглэлийг тодорхой болгож, төлөвлөгөөг гаргахдаа бусад салбартай /төрийн байгууллагатай/ уялдуулан давхардалгүй, боловсронгуй болгох;
 - Төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг шалгах, хуулиар хүлээсэн эрх үүргийг хэрэгжүүлдэг болгох арга хэмжээ авах;
 - Төв лабораторийн хүчин чадлыг сайжруулж, нэмэгдүүлэх
 - Төрийн байгууллагын ажлын уялдааг сайжруулан Улсын бүртгэлийн газраас хагас бүтэн жилээр улсын бүртгэлд шинээр бүртгүүлсэн, шилжилт хөдөлгөөн, үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн тухай бүртгэлийг авч цахим хяналтын системийг мэдээллийн баазыг шинэчлэх
 - Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэх цахим системийг боловсронгуй болгож, Шилэн хяналтын систем, эрсдэлийн үнэлгээтэй уялдуулах;
 - Шилэн хяналтын цахим системийг хялбаршуулах, боловсронгуй болгох;
 - Хүнсний аюулгүй байдал fsi.gov.mn бүртгэл мэдээллийн санд орсон мэдээллийг ашиглахад хялбар болгож, программыг шинэчлэх;
 - Хагас жил, жилийн эцсийн тайланг олон загвараар гаргаж, цаг хугацаа, цаас их хэмжээгээр үрсэн ажил болж байна. Тиймээс төрийн албаны зөвлөлөөс гаргасан дүрэм журамтай уялдуулан тайлан, мэдээг авах

2. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

- Импортын бодис, бараа бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулсан тохиолдолд шинжилгээний хариу гарах хүртэл хугацаанд түр битүүмжлэн хадгалах стандартын шаардлага хангасан хяналтын байгууллагын агуулахтай болох асуудлыг шийдвэрлэх;
- Барилга угсралтын үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ /захиалагч/ -аас гарах ХАБЭАТХ-ын 26 дугаар зүйлд заасан хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд зарцуулах хөрөнгийн санхүүжилт олгохдоо “тусгай санд” төвлөрүүлэн гүйцэтгэгч ААНБ-д олгох, гүйцэтгэлийн хяналтын байгууллага хяналт тавин ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэх.
- Таван толгой түлш ХХК-ийн шахмал түлшний үйлдвэрийн хашаан дахь болон Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хорооны Тахилтад ил задгай хураасан түлшийг Сайжруулсан хатуу түлш. Техникийн шаардлага MNS 5679:2019 стандартын 6.1 дэх

хэсэгт зааснаар зориулалтын агуулахад шилжүүлж, стандартын шаардлага хангасан түлшийг хэрэглэгчдэд хүргэх

➤ Лабораторийн шинжилгээний хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан сорьц, дээж авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, иоджуулсан давснаас бусад баяжуулсан бэлэн бүтээгдэхүүнд шинжилгээ хийх батлагдсан шинжилгээний арга аргачлал байхгүй иймд батлагдсан арга аргачлалтай болох

➤ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг дагаж гарах дүрэм, журмуудыг яаравчлан боловсруулж, батлуулж мөрдүүлэх;

➤ Хүнсний жижиг дунд үйлдвэрүүдэд тавигдах шаардлагын стандартыг гаргах нь зүйтэй байна. Хэрчсэн гурил, бууз банш, квас, нарийн боовны үйлдвэрлэлийн ерөнхий шаардлагын стандарт боловсруулж гаргахгүй бол шинээр үйл ажиллагаа эрхлэгчид огт ойлголтгүйгээр үйлдвэр явуулахаар байна.

➤ Гулууз буюу тураг мах, сүү зэрэг мал, амьтны гаралтай уут, савлагаагүй түүхий эд бүтээгдэхүүнд хаяг, шошго хэрэглэх арга аргачлал боловсруулж, шошгын стандартад нэмэлт өөрчлөлт оруулж мөрдөх нь зүйтэй байна.

➤ Хүнсний бүтээгдэхүүний техникийн ерөнхий шаардлагын стандартуудыг шинэчлэх, стандарт, техникийн ерөнхий шаардлага байхгүй хүнсний бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг боловсруулж гаргах нь зүйтэй байна. 70, 80 оны бүтээгдэхүүнүүдийн стандарт техникийн ерөнхий шаардлага нь одоогийн бүтээгдэхүүнд тохирдоггүй, ямар ч стандартгүй тахианы махан хиам, зайдас, элэгний нухаш, цагаан будааны боов, бэйкери үйлдвэрлэгдсээр байна. Бүтээгдэхүүний шошгод байгаа тэжээлэг чанар, илчлэг, уураг, нүүрс ус, тослогийн хэмжээ зөрүүтэй бодитой бус, ижил бүтээгдэхүүнүүдийг нэг нэгнээсээ хуулбарлаж тэмдэглэдэг асуудал их байна.

➤ Монгол Улсад мөрдөгдөж байгаа хуванцар савны стандартыг шинэчлэх шаардлагатай байна. Иргэдийн мэдлэг, мэдээлэл дутуу дулимагаас зориулалтын бус хуванцар савыг ундны усыг зөөвөрлөх, халааж хэрэглэж болохгүй хүнсний саванд хоол хүнсийг халаах зэргээр ашиглах зэрэг эрсдэл үүсч байна.

3. Ажиллагсдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар:

➤ Мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчид, улсын байцаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр судалгаа хийж, төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний хүрээнд хөнгөлөлттэй нөхцөлөөр түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамруулах, орон байрны нөхцөлөө сайжруулах, зуслангийн газартай болоход нь үе шаттай дэмжлэг үзүүлэх;

➤ Мэргэжлээс шалтгаалах өвчний эрүүл мэндийн үзлэгт албан хаагчдыг хамруулж байх

➤ Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодод ажиллах эргүүл, хяналтын 12 ажилтанд улсын байцаагчийн эрх олгох асуудлыг шийдвэрлэх

- Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай багаж, техник хэрэгсэл /хэмжилтийн багажууд, зөөврийн компьютер, зургийн аппарат, диктафон, бусад/-ийн хангамж хүрэлцээг сайжруулах, автомашины хүрэлцээг нэмэгдүүлэх
- Байцаагчдад шалгалт хийхэд шаардлагатай гүний болон зайнаас хэмжих термометр, чийглэг хэмжигч, рН метр, индикаторууд зэрэг үйлдвэрийн орчин, бүтээгдэхүүний шинж байдлыг газар дээр нь тодорхойлох сүүлийн үеийн дэвшилтэт технологитой өндөр мэдрэмжтэй хэмжих хэрэгслүүдээр хангах нь чухал байна. Хүнсний үйлдвэрийн бичил орчины нөхцөл шаардлагыг тодорхойлох, тосны хуучралт, тосны хүчлийн тоо, бүтээгдэхүүний рН, хүчиллэг, чанарыг газар дээр нь түргэн хугацаанд тодорхойлох орчин үеийн багаж, техник хэрэгслээр байцаагч нарыг хангах
- Албан хаагчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэлээр хангах, ажиллах нөхцлийг сайжруулах
- Гүний гаалийн хяналтын талбайд ажиллаж буй улсын байцаагчдыг ажиллах нөхцөл, сорьц авах зориулалтын сав, дээж түр хадгалах хөргөгч, компьютер техник төхөөрөмжөөр зохих төвшинд хангах;
- Улсын байцаагчдыг гадаад, дотоодын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын үйл ажиллагаа, техник технологийн хөгжилтэй танилцуулах, туршлага судлуулах ажлыг өргөжүүлэх,
- Албан хаагчдыг сертификаттай сургалтанд хамрагдах зардлыг төсөвд суулгаж өгөх

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Л.ЭРДЭНЭЧУЛУУН

ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

М.БАЯНМӨНХ

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ

М.НАРАНДУЛАМ

ТАЙЛАН НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:


ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Х.БАЙГАЛЬ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

1. Төлөвлөгөөт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний гүйцэтгэл


/График -1/



2020 онд НМХГ-ын хэмжээнд давхардсан тоогоор **5321** төлөвлөгөөт шалгалт, **2790** төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар **2268 (42.6%)** төлөвлөгөөт шалгалт, **619 (22.2%)** төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна./Шилэн хяналтын цахим системээс 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар/

2. 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хавсралтаар батлагдсан бусад хяналтын хэрэгжилт


/График -2/



НМХГ-аас 2020 оны эхний хагас жилийн байдлаар 5805 объектод урьдчилан сэргийлэх шалгалт, 298 объектод хяналт шинжилгээ, 448 объектод тандалт судлагаа, 202 объектод салбарын сургалт, 313 объектод хянан баталгаажуулах үйл ажиллагаа хийсэн байна./Шилэн хяналтын цахим системээс 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар/

3. Объектын эрсдэлийн үнэлгээ

/График - 3/




2019 онд нийт **44851** объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн нь өмнөх оноос 747 объект буюу **1.7хувиар өссөн** үзүүлэлттэй байна. Нийт объектод их эрсдэлтэй объектын эзлэх хувь өмнөх оноос 0.3 пунктаар буурсан.

ХАВСРАЛТ 2

2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ӨНГӨРСӨН ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛСАН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

1. Улсын байцаагчийн үйлдсэн баримт бичгийн үзүүлэлт



/График - 4/


Улсын байцаагчдын үйлдсэн акт, албан шаардлага, албан даалгавар, дүгнэлт, зөвлөмжийг авч үзвэл дүгнэлт 9.1 хувиар, акт 23.3 хувиар, албан шаардлага 47.4%, албан даалгавар 5.5%-иар тус тус буурсан бол зөвлөмжийн тоо 0.7%-иар өссөн байна.

2020 оны эхний хагас жилд актын биелэлт 81.8 хувьтай, албан шаардлагын биелэлт 67.0 хувьтай, албан даалгавар 85.4 хувьтай биелэгдсэн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад актын биелэлт 7.4 хувиар буурч, албан шаардлагын биелэлт 19.3 хувиар, албан даалгаврын биелэлт 9.7 хувиар тус тус өссөн байна.


Улсын /ахлах/ байцаагчдын үйлдсэн дүгнэлт

/График - 5/

Улсын байцаагчдын үйлдсэн үйл ажиллагааны дүгнэлт 16.3 хувиар, бүтээгдэхүүний дүгнэлт 8.1 хувиар тус тус буурсан бол ажлын байрны дүгнэлт 47.9 хувиар өссөн байна.



2. Үйл ажиллагааг зогсоосон, сэргээсэн үзүүлэлт



/График - 6/


2020 оны эхний хагас жилд хууль тогтоомжийн дагуу зөрчил гаргасан 56 байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, 18 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг сэргээсэн нь өмнөх оноос үйл ажиллагааг түр зогсоосон аж ахуйн нэгжийн тоо 2.1 дахин, үйл ажиллагааг сэргээсэн аж ахуй нэгжийн тоо 1.8 дахин тус тус буурсан байна.

3. Нөхөн төлбөр, торгууль, түүний барагдуулалт /мян.төг/

/Хүснэгт-1/


Үзүүлэлтүүд	2019-II	2020-II	Хувь
Тогтоосон торгууль	1 887 116.7	1 677 685.0	11.1% буурсан
Барагдуулсан	1 503 010.8	1 368 391.0	9.0% буурсан
Хугацаа болоогүй	359 356.0	332 674.0	7.4% буурсан
Нийт барагдуулалтын хувь	79.6%	81.6%	2.0% өссөн
Тогтоосон нөхөн төлбөр	403 036.3	660 848.8	1.6 дахин өссөн
Барагдуулсан нөхөн төлбөр	360 659.3	527 027.7	1.4 дахин өссөн
Хугацаа болоогүй	42 377.0	162 799.0	3.8 дахин өссөн
Хүчингүй болсон	0	0	-
Нийт барагдуулалтын хувь	89.5%	79.8%	9.7% буурсан.

/График - 7/



2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1,667,685.0 мянган төгрөгийн торгууль тогтоосон нь өмнөх оны мөн үеэс 209,432.0 мянган төгрөг буюу 11.1%, барагдуулсан торгууль 134,620.0 мянган төгрөгөөр буюу 9.0% тус тус өссөн байна.


/График - 8/



Хяналт шалгалтаар нийт 660,848.8 мянган төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, 527,027.7 мянган төгрөг буюу 79.8 хувийг барагдуулсан нь өмнөх оны үеэс тогтоосон нөхөн төлбөр 1.6 дахин, барагдуулалт 1.4 дахин тус тус өссөн дүнтэй байна.

4. Улсын орлого болгосон, хурааж устгасан эд зүйлс /мян.төг/


Улсын орлого болгосон эд зүйлийн дүн 7,606.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 7,680.7 мянган төгрөг буюу 2.0 дахин буурсан байна. Мөн 403,236.0 мянган төгрөгийн эд зүйлсийн хурааж устгасан нь өмнөх оноос 79,275.0 мянган төгрөгөөр буюу 24.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



5. Хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн үзүүлэлт

2020 оны эхний хагас жилд 19454 зөрчил илрүүлж, 13688 зөрчил буюу 70.4 хувийг богино хугацаанд арилгуулан ажилласан байна. Зөрчил арилгуулалтын хувь өмнөх оны мөн үеэс 4.2%-иар өссөн дүнтэй байна.


/График -10/



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад илрүүлсэн зөрчил 6805 (25.9%)-иар, арилгуулсан зөрчил мөн 3700(21.3%) хувиар тус тус буурсан байна.

6. Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

/График -11/




2020 оны эхний хагас жилд ирсэн албан бичгийн тоо өмнөх оны мөн үеэс 13.0 хувиар буурсан бол өргөдөл, гомдлын тоо 23.7 хувиар өссөн байна.

Албан бичгийн шийдвэрлэлт 90.4 хувь, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 93.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад албан бичгийн шийдвэрлэлт 0.2 хувиар, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 2.3 хувиар тус тус буурсан байна.


7. Хэвлэл мэдээллийн сурталчилгаа

/График -12/




Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилсан мэдээ мэдээллийн тоо өмнөх оны мөн үеэс 1018 буюу 28.7 хувиар буурсан байна.

8. Сургалт



Аж ахуйн нэгж, байгууллага иргэдэд зохион байгуулсан сургалтын тоо өмнөх оны мөн үеэс 157 сургалт буюу 2.8 дахин, улсын байцаагчдад зориулсан дотоод сургалтын тоо 226 сургалт буюу 3.5 дахин тус тус буурсан байна.

9. Зөвлөмж, мэдэгдэл




НМХГ-аас аж ахуйн нэгж, иргэдэд хүргүүлсэн зөвлөмж, мэдэгдлийн тоо өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар өссөн дүнтэй байна.

ХАВСРАЛТ 3

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

-МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР


/График -15/



■ Биелэлтийн хувь 100% /МХЕГ-т/

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд /МХЕГ/ 28 арга хэмжээ тусгагдсанаас 28 арга хэмжээ 100 хувьтай хэрэгжсэн байна.


Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд /НЗДТГ/ 14 арга хэмжээ тусгагдсанаас 12 арга хэмжээ 100 хувь хэрэгжиж, 2 арга хэмжээ үнэлэх боломжгүй байна.



■ Биелэлтийн хувь 100% /НЗДТГ-т/

-НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

/График -16/




■ Биелэлтийн хувь 83.0%

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндсэн хэрэгжүүлэх 2, хамтран хэрэгжүүлэх 7 буюу нийт 9 арга хэмжээ тусгагдсанаас 6 арга хэмжээ 100 хувь биеэлж, 1 арга хэмжээ 70 хувьтай, 2 арга хэмжээ 40 хувьтай байна.

-НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

/График -17/



■ Биелэлтийн хувь 81.0%

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд 9 заалт тусгагдсанаас 6 заалт 100 хувь биеэлж, 3 заалт хэрэгжих шатандаа байна.

-НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ, АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

/График -18/




Нийслэлийн Засаг даргын 13 захирамжийн 24 заалтаас 100 хувьтай бүрэн хэрэгжсэн 22, 30 хувьтай 2 заалт байна.

Захирамжийн биелэлийн хувь- **94.0%**

МХЕГ-ЫН ДАРГЫН ГАРГАСАН ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТ

/График -19/



Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газартай холбоотой 6 тушаалгарсан байна.

Биелэлтийн хувь **98.5%**


НМХГ-ЫН ДАРГЫН ГАРГАСАН ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТ

/График -20/

НМХГ-ын даргын А-57 тушаал, Б-255 тушаал буюу нийт 312 тушаал гарсан байна.

А тушаалын биелэлт **96.5%**

Б тушаалын биелэлт **100%**



---oOo---